



ХАЛДВАРТ ӨВЧИН
СУДЛАЛЫН ҮНДЭСНИЙ ТӨВИЙН
ЕРӨНХИЙ ЗАХИРЛЫН
ТУШААЛ

2014 оны 09 сарын 29 өдөр

Дугаар А/81

Улаанбаатар хот

Улирлын томуугийн эсрэг вакцинаар
дархлаажуулах тухай

Засгийн газрын 2011 оны 108 тоот тогтоолоор батлагдсан “Халдварт өвчинтэй тэмцэх үндэсний хөтөлбөр”, Эрүүл мэндийн сайдын 2009 оны 323 тоот тушаалыг хэрэгжүүлэх зорилгоор **ТУШААХ НЬ:**

1. Улирлын томуугийн эсрэг вакцины хуваарийг нэгдүгээр хавсралтаар, вакцины зааврыг хоёрдугаар, мэдээ өгөх хүснэгтийг гуравдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Эмч, эмнэлгийн ажилчид, эрсдэлт бүлгийн хүн амыг улирлын томуугийн эсрэг вакцинаар дархлаажуулах арга хэмжээг зохион байгуулахыг Дархлаажуулалтын албаны дарга (О.Дашпагам), Халдварт өвчний тандалт, судалгааны албаны дарга (А.Амбасэлмаа)-д үүрэг болгосугай.

3. Энэ тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Тандалт судалгаа эрхэлсэн дэд захирал (Г.Сүрэнханд)-д даалгасугай.

ЕРӨНХИЙ ЗАХИРАЛ



Д.НЯМХҮҮ

ХӨСҮТ-ийн ерөнхий захирлын 2014 оны 09
дугаар сарын 29-ны өдрийн 1/8 тоот тушаалын
нэгдүгээр хавсралт

Улирлын томуугийн эсрэг вакцины хуваарь

Нэг. Аймагт

Д/д	Аймгийн эрүүл мэндийн газар	Тарих хүний тоо	Вакцин (хүн тун)
1	Архангай аймгийн ЭМГ	850	850
2	Баян-Өлгий аймгийн ЭМГ	600	600
3	Баянхонгор аймгийн ЭМГ	1000	1000
4	Булган аймгийн ЭМГ	800	800
5	Говь-Алтай аймгийн ЭМГ	850	850
6	Говь-Сүмбэр аймгийн ЭМГ	300	300
7	Дархан-Уул аймгийн ЭМГ	250	250
8	Дорноговь аймгийн ЭМГ	500	500
9	Дорнод аймгийн ЭМГ	1500	1500
10	Дундговь аймгийн ЭМГ	700	700
11	Завхан аймгийн ЭМГ	450	450
12	Орхон аймгийн ЭМГ	200	200
13	Өмнөговь аймгийн ЭМГ	800	800
14	Өвөрхангай аймгийн ЭМГ	900	900
15	Сүхбаатар аймгийн ЭМГ	500	500
16	Сэлэнгэ аймгийн ЭМГ	800	800
17	Төв аймгийн ЭМГ	400	400
18	Увс аймгийн ЭМГ	700	700
19	Ховд аймгийн ЭМГ	400	400
20	Хөвсгөл аймгийн ЭМГ	1000	1000

21	Хэнтий аймгийн ЭМГ	450	450
	Нийт	13950	13950

Хоёр. Нийслэлд

д.д	Нэр	Тарих хүний тоо	Вакцин (хүн тун)
1	Эрүүл мэндийн яам	100	100
2	Улсын нэгдүгээр төв эмнэлэг	250	250
3	Улсын хоёрдугаар төв эмнэлэг	410	410
4	Улсын гуравдугаар төв эмнэлэг	300	300
5	Халдварт өвчин судлалын үндэсний төв	500	500
6	Хавдар судлалын үндэсний төв	200	200
7	Зооноз өвчин судлалын үндэсний төв	50	50
8	Эх хүүхдийн эрүүл мэндийн үндэсний төв	300	300
9	БХХСАХНЭ	300	300
10	Цус сэлбэлт судлалын үндэсний төв	60	60
11	Гэмтэл согог судлалын үндэсний төв	200	200
12	Эрүүл мэндийн хөгжлийн төв	60	60
13	Сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний төв	350	350
14	Нөхөн сэргээх хөгжлийн үндэсний төв	25	25
15	МШӨСҮТ	60	60
16	ШЭНЭШТ	60	60
17	Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын харьяа эмнэлэг	50	50

18	Нийслэлийн эрүүл мэндийн газар	70	70
19	Нялхасын клиник	50	50
20	СБД-ийн Эрүүл мэндийн нэгдэл	300	300
21	СБД-ийн Нэгдсэн эмнэлэг	130	130
22	ЧД-ийн Эрүүл мэндийн нэгдэл	200	200
23	ХУД-ийн Эрүүл мэндийн нэгдэл	300	300
24	ХУД-ийн Нэгдсэн эмнэлэг	50	50
25	БГД-ийн Эрүүл мэндийн нэгдэл	700	700
26	СХД Эрүүл мэндийн нэгдэл	400	400
27	СХД-ийн Нэгдсэн эмнэлэг	100	100
28	БЗД-ийн Эрүүл мэндийн нэгдэл	600	600
29	БЗД-ийн Нэгдсэн эмнэлэг	160	160
30	НАД-ийн Эрүүл мэндийн нэгдэл	200	200
31	БНД-ийн Эрүүл мэндийн нэгдэл	350	350
32	БХД-ийн Эрүүл мэндийн нэгдэл	50	50
33	Төмөр замын эмнэлэг	350	350
34	Яаралтай тусламжийн төв	350	350
35	Нэгдүгээр амаржих газар	200	200
36	Хоёрдугаар амаржих газар	115	115
37	Гуравдугаар амаржих газар	120	120
38	УАУТҮКорпораци	70	70
39	Сэргээн засах клиник эмнэлэг	70	70
40	Энэрэл эмнэлэг	90	90

41	“Гацуурт” ЭМТ	20	20
42	Гурван гал эмнэлэг	150	150
43	Сонгодо эмнэлэг	250	250
44	Дегфие шүдний эмнэлэг	50	50
45	Йонсей найрамдал эмнэлэг	50	50
46	Wellness med эмнэлэг	30	30
47	Элэг судлалын төв	50	50
48	Баянгол эмнэлэг	50	50
49	Зүтгэл найдвар эмнэлэг	30	30
50	Номуун эмнэлэг	110	110
51	Онцгой байдлын ерөнхий газар	1750	1750
52	Мэргэжлийн хяналтын ерөнхий газар	400	400
53	Нийслэлийн мэргэжлийн хяналтын газар	200	200
54	Цагдаагийн ерөнхий газар	1500	1500
55	Хил хамгаалах ерөнхий газар	850	850
56	Архивын хэрэг эрхлэх газар	100	100
57	Асрамжын газар	300	300
58	Монголын Дауны холбоо	100	100
59	ОНӨААТҮГ	900	900
60	“Автобуснэг” ХХК	650	650
61	ХӨСҮТ-ийн сайн дурын кабинет	15210	15210
	нийт	31050	31050

ХӨСҮТ-ийн ерөнхий захирлын 2014 оны 0.9
дугаар сарын 29-ны өдрийн 4/8, тоот тушаалын
хоёрдугаар хавсралт

Томуугийн идэвхигүйжүүлсэн вакцин(CS-Flu)-ыг хэрэглэх заавар

Бүтээгдэхүүний нэр: Томуугийн идэвхигүйжүүлсэн вакцин

Найрлага: Тухайн жилд хүн амын дунд давамгайлан эргэлдэж байгаа А болон Б хүрээний томуугийн вирусыг тахианы үр хөврөлд өсгөвөрлөн, вирусыг ялгаж, цэвэршүүлэн идэвхгүйжүүлж, дахин цэвэршүүлэх замаар гарган авсан вирус.

Дэлхийн эрүүл мэндийн байгууллагын зөвлөмж болгосны дагуу 2014-2015 онуудад дэлхийн бөмбөрцгийн хойд хэсэгт орчиж буй вирусээр томуугийн вакциныг бэлтгэхийг зөвлөмж болгож байна.

0.5 мл вакцин тутамд дараах вирусыг агуулж байгаа:

- А/Калифорни /7/2009 (H1N1) төст вирус 15 микрограм
- А/Техас /50/2012(H3N2) төст вирус..... 15 микрограм
- В/Массачусет/2/2012 төст вирус 15 микрограм

Онцлог шинж чанар: Вакцин нь бага зэрэг сүүн цагаан, тунгалаг шингэн хэлбэртэй бөгөөд гадны ямар нэг хольц агуулаагүй.

Савлалт: Тариурт 0.5 мл-ээр савлагдсан

Дархлаа үүсэх хугацаа: Вакцин тариулснаас 2-3 долоо хоногийн дараа томуугийн вирусын эсрэг бие үүсэх бөгөөд энэ нь улирлын томуугаас сэргийлнэ.

Вакциныг тарих тохиромжтой нас: 3-аас дээш насны хүүхэд болон насанд хүрэгчдэд вакциныг хийнэ.

Хэрэглэх заавар болон тун: 3-аас дээш насны хүүхдүүд болон насанд хүрэгчдэд бугалганы дээд хэсгийн делтойд булчинд 0.5 мл-ээр гүн тарина.

Вакцины хийлгэсний дараах хариу урвал:

- Вакцин хийлгэснээс хойш 12-24 цагийн дотор тарьсан хэсэгт улайх, хавдах, өвдөх зэрэг шинж тэмдэгүүд илэрч болох бөгөөд хэсэг хугацааны дараа өөрөө арилна.
- Булчин өвдөх, үе өвдөх, толгой өвдөх, толгой эргэх, хөлрөх, бие тавгүйрхэх, халуурах, чичрэх зэрэг шинж тэмдэгүүд вакцин хийлгэсний дараа гарч болно. Эдгээр нь 1-2 хоногийн дотор аяндаа алга болно.
- Харшлын урвал: Ховор тохиолдоно
- Ховор илэрч болох урвал: Мэдрэлийн судас үрэвсэх, татах, салганах, түр зуурын тромбоцитопени

- Маш ховор илэрч болох урвал: анафилаксын шок, васкулит, энцефаломиелит, неврит, Геллиен - Баррын хам шинж

Эсрэг заалт:

- Халуунтай, цочмог халдварт өвчтэй, томуутай хүмүүс
- Өндгөнд харшилтай болон харшлын түүхтэй хүмүүст хийж болохгүй.

Анхаарах зүйлс:

- Дархлаа султай хүмүүс вакцин хийлгэхээс өмнө эмчээс зөвлөгөө авах
- Судсаар тарьж хэрэглэж болохгүй
- Тарих явцад вакциныг халдваргүйтгэлийн бодист хүргэж болохгүй
- Вакцины шил цуурсан, шошго уншигдахгүй, хэвийн бус болон задардаггүй тунадас үүссэн тохиолдолд хэрэглэж болохгүй
- 1:1000 шингэрүүлэлт бүхий адреналиныг вакцинжуулалтын явцад яаралтай тохиолдолд хэрэглэх зорилгоор бэлтгэж тавина.
- Хадгалах хугацаа дуусахаас өмнө вакциныг хэрэглэ
- Хүүхэд хүрэхгүй газар хол байрлуул

Жирэмсэн болон хөхүүл үед:

- Энэ талаар хийгдсэн хангалттай судалгаа байхгүй. Эмчээс зөвлөгөө авсны үндсэн дээр вакцин хийлгэх эсэхээ шийдэх хэрэгтэй.

Бусад вакцинтай зохицох байдал:

- Уг томуугийн вакциныг бусад вакцинтай хамт хэрэглэж болох бөгөөд тарих талбай нь өөр өөр газар байх ёстой.
- Хэрэв иммуноглобулин тариулсан бол тарьснаас хойш нэг сарын дараа томуугийн вакциныг тариулах хэрэгтэй.

Хадгалалт: 2-8 хэмд харанхуй газар хадгална. Хөлдөөж болохгүй. Хадгалах хугацаа 12 сар.

Үйлдвэрлэгч: Чанчун Чансен Лайф Сайнс компани (Changchun Changsheng Life Science Ltd). № 1615 Yueda road, Changchun, China

ХӨСҮТ-ийн ерөнхий захирлын 2014 оны 09
 дугаар сарын 29-ны өдрийн 21/8 тоот тушаалын
 гуравдугаар хавсралт

Улирлын томуугийн вакцины мэдээ авах хүснэгт

Д.д	Байгууллагын нэр	Нийт хамрагдсан хүний тоо	3-4 нас	5-14 нас	15-19 нас	20-49 нас	50-64 нас	65-аас дээш
 ЭМГ							
 НЭ							
 ӨЭМТ							
 Сумын ЭМТ							
	Бусад (Онцгой байдлын газар, цагдаагийн газар, мэргэжлийн хяналтын газар, хил гаалийн газар гэх мэт байгууллагын нэрийг бичих)							

Тайлбар: Вакцины хамралтын мэдээг дээрх хүснэгтийн дагуу 2014 оны 10 дугаар сарын 13-ны дотор дархлаажуулалтын албаны 451798, 88045064 тоот утсаар мэдээллэх.